# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
# ТУШААЛ

2021 оны 12 сарын 09 өдөр Дугаар А/760 Улаанбаатар хот

**“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг нэгдүгээр, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Эмнэлгийн тусламж,үйлчилгээний газар (Ж.Нарангэрэл), Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд), Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ц.Алтантуяа), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа)-д тус тус даалгасугай.

3. Тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны дотор тус яамны Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т ирүүлэхийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ц.Алтантуяа)-д үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүр төсөвт тусган ажиллахыг Санхүү, эдийн засгийн газар (Б.Мөнхтуул)-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

САЙД С.ЭНХБОЛД

141220216

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 09 ний өдрийн А/760 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# “ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ /2021-2024 ОН/

**ЗОРИЛГО:** Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах.

**ЗОРИЛТ 1.** Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх зүйн орчинг сайжруулж, түншлэл, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх

**ЗОРИЛТ 2.** Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нөөцийг бэхжүүлэн, зохистой удирдах

**ЗОРИЛТ 3.** Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тандалтыг сайжруулан, тэргүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа хийх, нотолгоонд суурилан орчин үеийн оношилгоо, эмчилгээний дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлж, нутагшуулах

**ЗОРИЛТ 4.** Хүн амын дунд эх, хүүхэд, нөхөн үржихүйн чиглэлээр орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндийн боловсрол олгож мэдлэг, хандлага, дадлыг дээшлүүлэн, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах замаар ээлтэй орчин бүрдүүлэх

**ЗОРИЛТ 5.** Эх, ураг, нярай, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хүрэх үр дүн | | | | Хариуцах байгууллага | Хамтрах байгууллага | Төсөв (сая) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | | | |
| **ЗОРИЛТ 1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх зүйн орчинг сайжруулж, түншлэл, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх** | | | | | | | | |
| 1. | “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-ийг аймаг, нийслэлийн Засаг даргаар ахлуулан байгуулах | | Зөвлөлийн ажиллах журам батлуулсан байна | Жилийн ажлын төлөвлөгөө гарган, үнэлгээ хийгдэж, улсын зөвлөгөөнд танилцуулсан байна | Зөвлөлийн ажлын үр дүнг аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлсэн байна | ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл | Аймаг нийслэл дүүрэг, сум, хорооны ЗДТГ | ОУБ |
| 2. | Эрүүл мэндийн сайд, Засаг даргатай байгуулах жил бүрийн гэрээнд эх, хүүхдийн эндэгдэл, нөхөн үржихүйн насны | | Тусгай шалгуур үзүүлэлтийг боловсруулан | Гэрээний үр дүнг үнэлсэн байна | Гэрээний үр дүнг үнэлсэн байна | ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл | Аймаг нийслэл дүүрэг, сум, | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг тусган, дүгнэх | | гэрээнд тусгасан байна | | | | хорооны ЗДТГ | |
| 3. | Улсын болон нийслэлийн хэмжээнд эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгон томьёолох | Одоогийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа чиг үүргүүдийг тодорхойлох | Тусламж, үйлчилгээний чиг үүргийг томьёолон баталгаажуулсан байна | Улсын болон нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ өргөжсөн байна | | ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл | ЭХЭМҮТ ЭНЭҮТ -II Амаржих газрууд | - |
| 4. | ЭХНҮЭМ-ийн тусламж үйлчилгээний чиглэлээр шийдвэр гаргагч болон хувийн хэвшил, ТББ-уудад олон нийтийн оролцоо түншлэлийг нэмэгдүүлэх ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах | Ухуулга нөлөөллийн ажлын төлөвлөгөө төсөл боловсруулсан байна | Ухуулга нөлөөллийн ажлын төлөвлөгөө батлагдаж, хэрэгжиж эхэлсэн байна | Төлөвлөгөөний хэрэгжилт 80% хийгдсэн байна | Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байна | ЭХЭМҮТ НЭМҮТ | МЭБЭЭНХ ОУБ-ууд | Улсын төсөв<br>300.0 |
| 5. | Жирэмсний хяналт болон хүүхдийн зарим тусламж, үйлчилгээг хувийн хэвшлийн эмнэлгүүдээр гүйцэтгүүлэх зохицуулалтыг шинэчлэх санал боловсруулж хэрэгжүүлэх | Жирэмсний хяналт болон хүүхдийн зарим тусламж, үйлчилгээг хувийн хэвшлийн эмнэлгээр гүйцэтгүүлэх саналын төслийг боловсруулсан байна. | Жирэмсний хяналт болон хүүхдийн зарим тусламж, үйлчилгээг хувийн хэвшлийн эмнэлгээр гүйцэтгүүлэх хэрэгцээ, нөхцөл байдлын үнэлгээ хийж ачааллын тооцоолол гаргасан байна | Хувийн хэвшлийн эмнэлэг жирэмсний хяналт болон хүүхдийн зарим тусламж, үйлчилгээг гүйцэтгүүлэх эсэхийг шийдвэрлэсэн байна | Хувийн хэвшлийн эмнэлэг дээр хийгдэж буй жирэмсний хяналт болон хүүхдийн зарим тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн үнэлгээ хийгдсэн байна. | ЭМЯ ЭМДЕГ ЭМХТ | Төр болон хувийн хэвшлийн эмнэлгүүд | - |
| 6. | Эх барих, эмэгтэйчүүдийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх бодлогын бичиг баримт боловсруулах | Бодлогын бичиг баримтын төсөл боловсруулсан байна | Бодлогын бичиг баримтын төслийг батлуулсан байна | Бодлогын бичиг баримтын хэрэгжилт эхэлсэн байна | | ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл | ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд | - |
| 7. | Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд "Эх, хүүхдэд ээлтэй байгууллага"-ын шалгуурыг шинэчлэн боловсруулж салбар бүрээр шалгаруулж, олон нийтэд жил бүр сурталчилдаг болох | Удирдамж боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан байна | Эх, хүүхдэд ээлтэй байгууллагыг 1-3 одоор эрэмбэлэн үнэлэх удирдамж батлагдсан байна. | Шалгуурын дагуу байгууллагууда д үнэлгээ хийж, шалгаруулан олон нийтэд | Шалгуурын дагуу байгууллагууда д үнэлгээ хийж, шалгаруулан олон нийтэд | ЭМЯ ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II НЭМҮТ | Худалдаа аж үйлдвэрийн танхим ТББ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв<br>160.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сурталчилсан байна. | сурталчилсан байна. | | | |
| 8. | "Эх, хүүхдэд ээлтэй Эрүүл мэндийн байгууллага"-аар шалгарахад дэмжлэг үзүүлэхийн тулд иргэний нийгэм, олон нийт, хувийн хэвшлийг татан оролцуулахад чиглэсэн ухуулга нөлөөлөл, сурталчилгаа хийх | | Шалгуур үзүүлэлт боловсруулан батлуулсан байна. | Ухуулга сурталчилгаа зохион байгуулсан байна. | Шалгуурын дагуу байгууллагууда д үнэлгээ хийж, дүгнэсэн байна. | ЭМЯ ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II НЭМҮТ | Аймаг нийслэл дүүрэг, сум, хорооны ЗДТГ ОУБ-ууд | Улсын төсөв 150.0 |
| 9. | "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" улсын зөвлөгөөнийг жил тутам зохион байгуулах | | Улсын зөвлөгөөн зохион байгуулагдаж, зөвлөмж гарсан байна | Улсын зөвлөгөөн зохион байгуулагдаж, зөвлөмж гарсан байна | Улсын зөвлөгөөн зохион байгуулагдаж, зөвлөмж гарсан байна | ЭМЯ ЭХЭМҮТ МЭБЭЭНХ МХАА | ЭНЭҮТ-II Аймаг нийслэл дүүрэг, сум, хорооны ЗДТГ Амаржих газрууд, Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв 50.0 |
| 10. | Хүүхэд хамгааллын чиглэлээр бусад салбартай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтран ажиллах (Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөг, хүүхдийн осол гэмтэл, сургууль завсардалт гм) | Хүүхэд хамгааллын чиглэлээр бусад салбартай хамтран ажиллах чиглэлийг боловсруулсан байна. | Сонгосон салбаруудтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан байна | Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийн хангаж ажиллана | Сонгосон салбаруудтай харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийн үнэлгээ хийгдсэн байна | ЭМЯ ГССҮТ СЭМҮТ | БСШУЯ ЦЕГ ХНХЯ Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төв Хүчирхийлл ийн эсрэг үндэсний төв | Улсын төсөв 80.0 |
| 11. | Өрхийн ЭМТ-ийн гурвалсан гэрээнд заасан эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний хэрэгжилтэд үнэлгээ хийж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулах | Гурвалсан гэрээнд оруулах саналын төслийг боловсруулсан байна. | Үнэлгээ хийгдэж, тайлан зөвлөмж гарсан байна | Зөвлөмжийг хэрэгжүүлж эхэлсэн байна | Зөвлөмжийн хэрэгжилтийг хэрэгжүүлж ажилласан байна. | ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл | Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ОУБ-ууд | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12. | Перинатологийн (Эх Ургийн Анагаах Ухаан) төвийг үе шаттайгаар бүсчилэн байгуулах | Перинатологийн төвийг бүсчилэн байгуулах зураглал гаргасан байна | Перинатологийн төв байгуулах шийдвэр гарсан байна | Перинатологийн төвийн үйл ажиллагааг нийслэлд эхлүүлэн, тогтмолжуулсан байна | Перинатологийн төвийн үйл ажиллагааг 1-2 бүс нутагт эхлүүлэн, тогтмолжуулсан байна | ЭМЯ ЭХЭМҮТ Мэргэжлийн салбар зөвлөл | Аймгийн ЭМГ-үүд ОУБ-ууд | Улсын төсөв 1,510.0 |
| 13. | Хүүхэд, жирэмсэн, Нөхөн үржихүйн насны болон жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэнд, тусламж, үйлчилгээний мэдээлэл, хяналтын нэгдсэн системийг бий болгох | Одоогийн бүртгэлийн системд үнэлгээ хийгдсэн байна | Мэдээллийн нэгдсэн сантай болгох суурь тавигдсан байна | Мэдээллийн нэгдсэн сан үүссэн байна | | ЭМЯ ЭХЭМҮТ ЭМХТ | Амаржих газрууд Аймгийн ЭМГ-үүд ОУБ-ууд | Улсын төсөв 400.0 |
| **ЗОРИЛТ 2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний нөөцийг бэхжүүлэх, зохистой удирдах** | | | | | | | | |
| 1. | Эмэгтэйчүүд, жирэмсэн, төрөлт, төрсний дараах үед зонхилон тохиолдох эмгэгийн болон нярайн тусламж үйлчилгээний өртгийг шинэчлэн тооцох | Өртөг тооцох байгууллагыг сонгон шалгаруулах төслийг боловсруулсан байна | Өртөг тооцох судалгаа хийгдсэн байна | Сонгосон тусламж үйлчилгээг даатгалаас санхүүжүүлэх зардлын хэмжээ шинэчлэгдэн, хэрэгжилт эхэлсэн байна | | ЭМЯ ЭМДЕГ ЭМХТ | Холбогдох ЭМБ-ууд ДЭМБ | - |
| 2. | Орчин үеийн ЖХАХ-ийн хүртээмжтэй байдал, санхүүжилтийн механизмын үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулах | Үнэлгээ хийх байгууллага сонгон шалгаруулах төслийг боловсруулсан байна | Үнэлгээ хийгдэн, тайлан гарч, зөвлөмж боловсруулсан байна | Үнэлгээний зөвлөмжид тулгуурлан холбогдох заавар журамд өөрчлөлт оруулсан байна | Зөвлөмжийг Эрүүл мэндийн байгууллагууд үйл ажиллагаандаа мөрдлөг болгосон байна | ЭМЯ ЭМДЕГ ЭМХТ | Холбогдох ЭМБ-ууд НҮБ-ын ХАС | ОУБ |
| 3. | Ураг, нярай, хүүхэд, өсвөр үеийн зарим эмгэгийн эрт илрүүлэг, жирэмсний болзошгүй хүндрэлийн эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмгэгийн эмчилгээ зэрэг тусламж үйлчилгээний ЭМД-ын санхүүжилтийг нэмэгдүүлэх | Санхүүжилт нэмэгдүүлэх шаардлагатай тусламж үйлчилгээний жагсаалт гарсан байна. | Жагсаалтын дагуу эдийн засгийн тооцоо хийгдсэн байна | Сонгосон тусламж, үйлчилгээг ЭМД-аас санхүүжүүлэх зардлын хэмжээ шинэчлэгдсэн байна. | Хэрэгжиж эхэлсэн байна | ЭМЯ ЭМДЕГ ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II Амаржих газар | Мэргэжлийн салбар зөвлөл Мэргэжлийн нийгэмлэг, холбоо | Улсын төсөв 20.0 |
| 4. | ДЭМБ-аас шинэчлэн гаргасан "Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлийг удирдах арга зүй" | | Сургалтын багц хөтөлбөр боловсруулж, | Сургалт зохион байгуулж, үр | Улсын хэмжээнд | ЭМЯ ЭХЭМҮТ АШУҮИС | Амаржих газрууд | ОУБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдамж болон зөвлөмжүүдийг нэвтрүүлэх сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах | | батлуулсан байна | дүнг тооцсон байна | хэрэгжсэн байна | | Аймгийн ЭМГ-ууд НҮБ-ын ХАС ТББ-ууд | |
| 5. | Uptodate олон улсын цахим платфорыг ашиглан Эх, хүүхэд нөхөн үржихүйн шинэ удирдамж, заавар боловсруулах ажлыг зохион байгуулах | Uptodate олон улсын цахим платформыг хэрэглээнд нутагшуулах үндэсний сургагч багшийг бэлтгэсэн байна | Uptodate олон улсын цахим платформ сургалтыг тасралтгүй явуулсан байх, шинэ удирдамж, зааврыг боловсруулсан байна | Боловсруулсан удирдамж, зааврын тоо нэмэгдсэн байна | | ЭМЯ ЭМХТ ЭЭХХЗГ ЭМДЕГ | Мэргэжлийн салбар зөвлөл Мэргэжлийн нийгэмлэг, холбоо | ОУБ |
| 6. | Өсвөр үе судлал, охидын эмчийг төрөлжсөн мэргэшлээр суралцах боломжтой мэргэжлийн жагсаалтад эх барих, эмэгтэйчүүдийн эмчийг нэмж, шинэчлэх | Өсвөр үе болон охидын эмч бэлтгэх тогтолцоог үнэлэх ажлын хэсэг байгуулагдсан байна | Өсвөр үе судлал, охидын эмч төрөлжсөн мэргэшлээр суралцах боломжтой мэргэжлийн жагсаалт шинэчлэгдсэн байна | Эх, барих эмэгтэйчүүдийн эмчээс өсвөр үе судлал, охидын эмч бэлтгэж эхэлсэн байна | Эх, барих эмэгтэйчүүдийн эмчээс бэлтгэгдсэн өсвөр үе судлал, охидын эмч өсвөр үеийн кабинетад ажиллаж эхэлсэн байна | ЭМЯ ЭМХТ | ЭХЭМҮТ АШУҮИС Амаржих газрууд Аймаг нийслэлийн ЭМГ-ууд | - |
| 7. | “Эх ургийн анагаах ухааны” мэргэжилтэнг аймаг бүрт үе шаттайгаар бэлтгэх | | Сургалтын багц хөтөлбөр боловсруулж, батлуулсан байна | Сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон байна | Улсын хэмжээнд хэрэгжсэн байна | ЭМЯ ЭМХТ | ЭХЭМҮТ АШУҮИС Амаржих газрууд Аймаг нийслэлийн ЭМГ-ууд | Улсын төсөв 10.0 |
| 8. | Аймаг, нийслэлийн амаржих газруудын зөвлөх эмч нарт эмнэлзүйн нотолгоонд суурилсан сургалт явуулах | | Сургалтын багц хөтөлбөр боловсруулж, батлуулсан байна | Сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон байна | | ЭМЯ ЭХЭМҮТ | АШУҮИС Амаржих газрууд Аймаг нийслэлийн ЭМГ-ууд | Улсын төсөв 5.0 |
| 9. | ХӨЦМ, эрэмбэлэн ангилал, яаралтай тусламж, олон нийтэд түшиглэсэн ХӨЦМ-ийн сургалт зохион байгуулах | | Сургалтын багц хөтөлбөр боловсруулж, | Сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Улсын хэмжээнд хэрэгжсэн байна. | ЭМЯ Аймаг, НийслэлийН ЭМГ | Мэргэжлийн салбар зөвлөл ТББ-ууд | Улсын төсөв 20.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | батлуулсан байна. | | | | ОУБ-ууд | |
| 10. | ЭХНҮЭМ-ийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтнүүдийн чадавхид суурилсан ажлын байрны тасралтгүй сургалтын тогтолцоо бий болгох | Ажлын байрны тасралтгүй сургалтын захиалга, санал авсан байна. | Чадавхид суурилсан ажлын байрны тасралтгүй сургалтын санхүү, зохион байгуулалтыг зохицуулсан журам батлагдсан байна | Чадавхид суурилсан ажлын байрны сургалтын гэрээгээр аймаг, дүүргээс мэргэжилтэн суралцсан байна | 21 аймаг тус бүрээс зөвлөх эмч нар сургалтад хамрагдсан байна. | ЭМХТ ЭХЭМҮТ АШУҮИС | Аймаг нийслэлийн ЭМГ-ууд Мэргэжлийн нийгэмлэг холбоод ОУБ-ууд | Улсын төсөв 60.0 |
| 11. | Өсвөр үеийнхэнд ээлтэй тусламж, үйлчилгээг үзүүлэх сургуулийн эмч, эрүүл мэндийн анхан шатны эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах | Өсвөр үеийнхэнд ээлтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх хэрэгцээг тодорхойлох хэлэлцүүлэг зохион байгуулсан байна | Өрх, сургуулийн эмч нарт өсвөр үеийнхний эрүүл мэндийн хэрэгцээг ойлгож, ээлтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулсан байна | Өсвөр үеийн тусламж, үйлчилгээний мэргэжлийн ном, гарын авлага хэвлэгдэн гарч ЭМАШТ сургуулийн эмч нарт түгээгдсэн байна | Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч нарыг сургасан байна | ЭМЯ ЭХЭМҮТ ЭМХТ | Мэргэжлийн нийгэмлэг, холбоод ТББ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв 40.0 |
| 12. | Ургийн мэс засалч, ихсийн пато-гистологич, хүүхдийн хөгжил зан төрхийн мэргэжилтэнг олон улсад сургаж бэлтгэх | | Төрийн сангаас эдгээр чиглэлээр суралцуулах захиалга өгсөн байна | Сонгосон чиглэлээр мэргэжилтэн сургагдсан байна | Сонгосон чиглэлээр мэргэжилтэн сургагдсан байна | ЭМЯ ЭМХТ | ЭХЭМҮТ ХБХСЗТ | Улсын төсөв 400.0 |
| 13. | Хүүхдийн мэдрэл, хүүхдийн мэс засал, хүүхдийн мэдээгүйжүүлэг, перинатологич, хүүхдийн хэл засалч, хөдөлгөөн засалч эмчийг орон тоогоор ажиллуулахыг гүйцэтгэлийн гэрээнд тусгах | Гүйцэтгэлийн гэрээний шалгуурт тусгахтай холбоотой тооцоо судалгаа хийсэн байна. | Гүйцэтгэлийн гэрээний шалгуурт оруулсан байна. | Хүүхдийн мэдрэл, хүүхдийн мэс засал, хүүхдийн мэдээгүйжүүлгийн эмч, перинатологич, хүүхдийн хэл засалч, хөдөлгөөн | Хүүхдийн мэдрэл, хүүхдийн мэс засал, хүүхдийн мэдээгүйжүүлгийн эмч, перинатологич, хүүхдийн хэл засалч, хөдөлгөөн | ЭМЯ ЭМХТ | ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II АШУҮИС | Улсын төсөв 20.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | засалч эмчийг орон тоогоор ажиллуулдаг эмнэлгийн тоо нэмэгдсэн байна | засалч эмчийг орон тоогоор ажиллуулдаг эмнэлгийн тоо нэмэгдсэн байна | | | |
| 14. | Нярайн эрт илрүүлэг болон нярайн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах | Нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт гарсан байна | 7 аймаг 1 амаржих газрыг бүрэн хангасан байна | 7 аймаг 1 амаржих газрыг бүрэн хангасан байна | 7 аймаг 1 амаржих газрыг бүрэн хангасан байна | ЭМЯ | ЭХЭМҮТ, Аймаг, нийслэлийн ИТХ, ЗДТГ, ЭМГ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв<br>900.0 |
| 15. | Нярайн эрт үеийн нэн шаардлагатай болон амилуулах тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмч, эмнэлгийн мэргэжилтний жил тутмын гэрчилгээт сургалтыг нэвтрүүлэх | | Нярайн эрт үеийн нэн шаардлагатай болон амилуулах тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмч, эмнэлгийн мэргэжилтнийг жил тутам гэрчилгээтэй сургалтад хамруулдаг журам боловсруулах | Гэрчилгээт сургалтад жил бүр хамрагдаж буй эсэхэд үнэлгээ хийх | Нярайн эрт үеийн нэн шаардлагатай болон амилуулах тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч, эмнэлгийн мэргэжилтний жил тутмын гэрчилгээт сургалт нэвтэрсэн байна | ЭМЯ<br>ЭМХТ | ЭХЭМҮТ<br>АШУҮИС | Улсын төсөв<br>80.0 |
| 16. | Эх, барих эмэгтэйчүүд, нярай, хүүхдийн эмч бэлтгэх төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөрийг үнэлж нэгдсэн хөтөлбөртэй болгох | | Үнэлгээ хийгдсэн байна | Нэгдсэн хөтөлбөр батлагдсан байна | Нэгдсэн хөтөлбөр хэрэгжсэн байна | ЭМХТ | АШУҮИС Хувийн хэвшлийн сургуулиуд | - |
| 17. | Эх барихын тусламж үйлчилгээнд шаардлагатай урвалж биобэлдмэлээр хангах.Үүнд:<br>- Анти D иммуноглобулин<br>- В гепатитын иммуноглобулин | Урвалж биобэлдмэлд өртгийн тооцоолол хийгдсэн байна | Урвалж биобэлдмэлээр төрөх газрууд хангагдаж эхэлсэн байна | Эмнэлзүйн зааврыг хэрэгжүүлэх сургалт зохион байгуулсан байна | Үйл ажиллагаа тогтмолжсон байна | ЭМЯ ЭЭХХЗА Мэргэжлийн салбар зөвлөл | ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II Амаржих газрууд | Улсын төсөв<br>500.0 |
| **ЗОРИЛТ 3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тандалтыг сайжруулж, тэргүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа хийх, нотолгоонд суурилан орчин үеийн оношилгоо, эмчилгээний дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлж, нутагшуулах** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | ЭХНҮЭМ-ийн тандалт, бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог дараах чиглэлээр өргөжүүлэх. Үүнд:<br>• Эрт илрүүлэгт хамрагдсан эмгэгүүд<br>• Хүүхдийн зонхилон тохиолдох өвчлөл (хатгаа, суулгалт, перинаталь гм) | Тандалтыг өргөжүүлэх тэргүүлэх чиглэл тодорхойлогдсон байна | Эрт илрүүлэг бусад тэргүүлэх чиглэлийн тандалтын журам батлагдсан байна.<br><br>Холбогдох эмч, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулсан байна | Тандалтын тогтолцоо хэрэгжиж эхэлсэн байна.<br><br>Холбогдох эмч, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулсан байна | Тандалтын тогтолцоо бүрэн нэвтэрсэн байна | ЭМЯ<br>ЭМХТ<br>ЭХЭМҮТ | ЭНЭҮТ-II<br>Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд<br>ОУБ-ууд | Улсын төсөв<br><br>300.0 |
| 2. | Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээнд мөрдөгдөж байгаа удирдамж, журам, зааврын хэрэгжилтийг үнэлэх | | Үнэлгээ хийх заавар журмын жагсаалт гаргаж хэрэгжилтийг үнэлсэн байна | Үнэлгээнд суурилсан зөвлөмж гарсан байна | Зөвлөмж хэрэгжсэн байна | ЭМЯ<br>ЭХЭМҮТ<br>Мэргэжлийн салбар зөвлөл | ЭНЭҮТ-II<br>Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд<br>ОУБ-ууд | Улсын төсөв<br><br>40.0 |
| 3. | Коронавируст халдвартай жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхдийн эмнэлзүйн онцлог, хүндрэлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйл, алсын үр дагаврын цогц судалгаа хийх | | Судалгаа хийгдэж, зөвлөмж гарсан байна | Зөвлөмжийн дагуу холбогдох заавар, журамд өөрчлөлт оруулсан байна | Зөвлөмжийн хүрээнд гарсан заавар журмыг хэрэгжүүлж эхэлсэн байна | ЭМЯ<br>ЭХЭМҮТ | Амаржих газрууд<br>Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд | Улсын төсөв<br><br>50.0 |
| 4. | Нярай болон хүүхдийн өвчлөл, эндэгдлийн эрсдэлт хүчин зүйлс, орон нутагт тохирсон хариу арга хэмжээг тодорхойлох судалгааг хийж, зөвлөмж боловсруулах | | Судалгаа хийгдэж, зөвлөмж гарсан байна | Зөвлөмжийн дагуу холбогдох заавар журамд өөрчлөлт оруулсан байна | Зөвлөмжийг хэрэгжүүлж эхэлсэн байна | ЭМЯ<br>ЭХЭМҮТ | Амаржих газрууд<br>Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд<br>ОУБ-ууд<br>ТББ-ууд | Улсын төсөв<br><br>20.0 |
| 5. | "Эх барихын яаралтай тусламж, Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн өнөөгийн байдал, хэрэгцээний үнэлгээ"-г үндэсний хэмжээнд хийх | | Үнэлгээ хийгдэж, зөвлөмж гарсан байна | Үнэлгээний зөвлөмжид тулгуурлан холбогдох заавар журамд өөрчлөлт оруулсан байна | Үнэлгээний зөвлөмжид тулгуурлан "Эх барихын яаралтай тусламж"-ийн чадавхыг ЭМ-ийн бүх шатлалд | ЭМЯ<br>ЭХЭМҮТ<br>Мэргэжлийн салбар зөвлөл | ЭНЭҮТ-II<br>Амаржих газрууд<br>Аймгийн ЭМГ-ууд<br>ОУБ-ууд | Улсын төсөв<br><br>50.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бэхжүүлж эхлэсэн байна | | | |
| 6. | Эх барих эмэгтэйчүүд, НҮЭМ-ийн чиглэлээр орчин үеийн шинэ аргыг нэвтрүүлнэ. Үүнд:<br>- Эмэгтэйчүүдийн өвчний үед бичил инвазив мэс засал<br>- Эх барихын их хэмжээний цус алдалтаас сэргийлэх ангиографийн эмчилгээ<br>- Эмэгтэйчүүдийн үргүйдлийн оношилгооны шинэ аргыг нэвтрүүлэх /оффис-гистероскопи/<br>- Эрэгтэйчүүдийн үргүйдлийн үрийн сувгийг залгаж нөхөн сэргээх мэс засал<br>- Үр хөврөлийн лазер ажилбар<br>- Урогенокологийн шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх | Эмч, мэргэжилтний хэрэгцээг тооцоолсон судалгаа гаргасан байна | Эмч, мэргэжилтэнг бэлтгэж, тоног төхөөрөмжөөр хангасан байна | Мэс засал эмчилгээг хийж эхлэсэн байна.<br><br>Тусламж үйлчилгээний нэр төрөл, тоо нэмэгдсэн байна | Үр дүнг тооцож, шинэ дэвшилтэт технологиудыг нутагшуулсан байна | ЭМЯ ЭХЭМҮТ ЭМХТ Мэргэжлийн салбар зөвлөл | ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв<br><br>400.0 |
| 7. | Нярайн тусламж үйлчилгээнд орчин үеийн шинэ аргыг нэвтрүүлж, нутагшуулах. Үүнд<br>- Бүтэлтийн үеийн хөргөх эмчилгээ<br>- Нярайн зүрхний нээлттэй мэс засал<br>- Нярайн мэдрэл, дурангийн мэс засал<br>- Барокамер эмчилгээ | Эмч, мэргэжилтний хэрэгцээг тооцоолон гаргасан байна | Эмч, мэргэжилтэн бэлтгэж, тоног төхөөрөмжөөр хангасан байна | Шинэ эмчилгээг хийж эхлэсэн байна | Үр дүнг тооцож, технологийг нутагшуулсан байна | ЭМЯ ЭХЭМҮТ Мэргэжлийн салбар зөвлөл | ЭНЭҮТ-II Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв<br><br>400.0 |
| 8. | Ургийн эмчилгээний дараах шинэ аргыг нэвтрүүлнэ. Үүнд:<br>- лазер эмчилгээ<br>- шунт эмчилгээ<br>- зүрхний үйл ажиллагааны эмгэгийг эмийн аргаар эмчлэх<br>- нуруу, нугасны мэс заслын эмчилгээний арга<br>- умай доторх ургаг цус сэлбэх<br>- Өндөр давтамжит радио долгионоор түлэх эмчилгээ | | Санхүүжилтийг шийдвэрлүүлэх төлөвлөгөөний төсөл гарган батлуулсан байна | -Хүний нөөцийг багаар нь гадаадад сургаж бэлтгэж эхлэнэ.<br>-Тоног төхөөрөмжөөр хангана | Ургийн эмчилгээний 6 шинэ технологи нэвтэрч эхлэсэн байна | ЭМЯ ЭХЭМҮТ Мэргэжлийн салбар зөвлөл | ЭНЭҮТ-II Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв<br><br>2,500.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | Ургийн оношилгоонд дараах шинэ аргыг нэвтрүүлнэ. Үүнд:<br>- Даавар, иммунологийн шинжилгээ<br>- Ургийн хуйхны pH метр,<br>- лактат тодорхойлох,<br>- В стрептококкын халдвар илрүүлэх, В стрептококкын халдвар илрүүлэх, ураг орчмын шингэнд TORCH үзэх<br>- Цөсний хүчил тодорхойлох<br>- Фиброникотины сорил үзэх<br>- NIPT шинжилгээг хийх<br>- MICRO ARRAY шинжилгээг хийх<br>- Хорион биопси хийх | | Хүний нөөцийг багаар нь гадаадад сургаж бэлтгэж эхэлнэ<br><br>Тоног төхөөрөмжөөр хангана<br><br>Санхүүжилтийг шийдвэрлүүлнэ | ЭХЭМҮТ-д хийдэг болсон байна | Үр дүнг тооцож, технологийг нутагшуулж эхэлсэн байна | ЭМЯ | ЭХЭМҮТ Мэргэжлийн салбар зөвлөл | Улсын төсөв<br><br>500.0 |
| 10. | Эхийн эндэгдлийн "Итгэмжит лавлагаа" судалгааг хийнэ /2020-2023 оныг хамруулна/ | | Судалгаа хийгдсэн байна. | Судалгааны тайлан зөвлөмж гарсан байна. | Зөвлөмжийг хэрэгжүүлж эхэлсэн байна. | ЭМЯ | ЭХЭМҮТ МЭБЭЭЭХ ОУБ-ууд | Улсын төсөв<br><br>20.0 |
| 11. | ЭХЭМҮТ-ийн тандалт судлагааны албаны мэдээлэлийн тогтолцоог өргөжүүлэх (Үргүйдэл, бусад шаардлагатай тусламж г.м). | Модулийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна | Гарын авлага боловсруулах | Шаардлагатай Модулийг бүртгэлийн програмд хөрвүүлсэн байна | Модуль нэмэлтээр хөгжүүлсэн байна | ЭМЯ ЭХЭМҮТ | МЭБЭЭЭХ ОУБ-ууд | Улсын төсөв<br><br>10.0 |
| 12. | Жирэмсний хяналтын тогтолцоонд үнэлгээ хийх | Үнэлгээ хийх бэлтгэл ажлыг хангасан байна | 20-30 нэгжид хяналт үнэлгээ хийгдсэн байна Үнэлгээний тайлан | 60-80 нэгжид хяналт үнэлгээ хийгдсэн байна Үнэлгээний тайлан | 100 нэгжид хяналт үнэлгээ хийгдсэн байна Үнэлгээний тайлан | ЭМЯ | ЭХЭМҮТ МЭБЭЭЭХ ОУБ-ууд | Улсын төсөв<br><br>5.0 |
| **ЗОРИЛТ 4. Хүн амын дунд эх, хүүхэд, нөхөн үржихүйн чиглэлээр орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндийн боловсрол олгож мэдлэг, хандлага, дадлыг дээшлүүлэн, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах замаар ээлтэй орчин бүрдүүлэх** | | | | | | | | |
| 1. | Коронавируст халдвар "COVID-19" буюу цар тахалтай холбоотой жирэмсэн, нярай, хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан мэдээлэл, зан үйлийг өөрчлөх сургалт сурталчилгааг хэвлэл | ММС-ны материалыг бэлтгэсэн байн | 2-аас доошгүй олон нийтийн мэдээллийн сувгаар гарсан байна | 5-оос доошгүй олон нийтийн мэдээллийн сувгаар гарсан байна | Үйл ажиллагаа тогтмолжсон байна. | ЭХЭМҮТ НЭМҮТ | ЭНЭҮТ-II Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд Төрийн болон ТББ-ууд | Улсын төсөв<br><br>100,0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн байгууллагуудтай хамтран явуулах | | | | | | ОУБ-ууд | |
| 2. | Өсвөр үеийнхэнд үе тэнгийн зөвлөгч бэлтгэх олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг дэлгэрүүлэх | | 10 аймаг, 9 дүүрэгт эхлүүлсэн байна | 11 аймаг, 9 дүүрэгт эхэлсэн байна | 21 аймаг, 9 дүүрэгт Үе тэнгийн сургагч бэлтгэгдсэн байна | ЭМЯ ЭХЭМҮТ | НЭМҮТ БСШУЯ ТББ-ууд | Улсын төсөв 50.0 |
| 3. | Гэр бүл олон нийтэд чиглэсэн нярай, хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн талаар мэдээллийн бүх хэрэгсэл ашиглан хооллолт, хөдөлгөөн, эрүүл амьдралын зан үйлийн талаар сошиал медиа контентууд боловсруулах | | Тусгай хөтөлбөрөөр сургалт явуулах | Сургалтыг үргэлжлүүлэх | Үр дүнг дүгнэх | НЭМҮТ | ТББ-ууд Хэвлэл мэдээллийн байгууллага | Улсын төсөв 20.0 |
| 4. | Сургуулийн өмнөх боловсролоор хэвшүүлэх дадлыг тодорхойлж, мэргэжил арга зүйгээр ханган социал медиа контентууд боловсруулах | | Үнэлгээний тайлан зөвлөмж гарсан байна | Зөвлөмжийг хэрэгжүүлж эхэлсэн байна | Зөвлөмжийг хэрэгжүүлж эхэлсэн байна | НЭМҮТ | Мэргэжлийн нийгэмлэг, холбоод ТББ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв 20.0 |
| 5. | Хүүхдийг эхийн сүүгээр хооллох ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээрх сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх | | Төлөвлөгөө гарсан байна | Төлөвлөгөө 60 хувь хэрэгжсэн байна | Төлөвлөгөө 80 хувь хэрэгжсэн байна | НЭМҮТ | НҮБ-ын ХАС, ХС ДЭМБ МЭБЭЭНХ | Улсын төсөв 20.0 |
| 6. | Бүх шатны боловсролын байгууллагад эрүүл мэндийн хичээл заах багш нарт зориулсан цахим хичээлийн контент, заах аргачлал боловсруулж боловсролын салбарын цахим платформд байршуулж, хэрэгжүүлэх | | Нийслэлд эрүүл мэндийн хичээл заагч багш, дотуур байрны багш, НА-ыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан байна | Баруун болон зүүн бүсийн эрүүл мэндийн хичээл заагч багш, дотуур байрны багш, НА-ыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан байна | Хангайн болон төвийн бүсийн эрүүл мэндийн хичээл заагч багш, дотуур байрны багш, НА-ыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан байна | НЭМҮТ | БШУЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ-ууд | Улсын төсөв 250.0 |
| 7. | Оюутан залуучуудын төлөөллийг оролцуулсан "Эрүүл мэнд-Реформ" зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулах | | Төр болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, МСҮТ-ийг "Оюутны эрүүл мэндийг | Төр болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, МСҮТ-ийг "Оюутны эрүүл | Төр болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, МСҮТ-ийг "Оюутны эрүүл | ЭМЯ НЭМҮТ | БШУЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ ЭМГ-ууд | Улсын төсөв 50.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дэмжсэн жишиг байгууллага” шалгаруулах журмын төсөл боловсруулан, холбогдох байгууллагуудаас санал авч, хэлэлцүүлсэн байна | мэндийг дэмжсэн жишиг байгууллага” шалгаруулах журмын төсөл батлуулсан байна | мэндийг дэмжсэн жишиг дотуур байр ” шалгаруулж, олон нийтэд сурталчилж, дүгнэж, урамшуулсан байна | | Их, дээд сургуулийн захиргаа | |
| 8. | Бэлгэвч хэрэглэсний үр дүнгийн талаарх сургалт сурталчилгааны үйл ажиллагааг жил бүр зохион байгуулах | | Оюутны эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд “Бэлгэвч” компанит ажлыг зохион байгуулсан байна | “Бэлгэвч” компанит ажлыг иргэдийн дунд зохион байгуулсан байна | “Бэлгэвч” компанит ажлын үр дүнг судлан, үнэлгээ хийсэн байна | НЭМҮТ | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар НҮБХАС | ОУБ |
| 9. | Эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжлэгт орчинг бүрдүүлэхэд их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн удирдлагын багийг оролцуулсан ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах | | Төр болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, МСҮТ-тэй хамтарсан ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө гаргасан байна | Асуудал хөндсөн хэлэлцүүлэг 3-4 удаа (бодлого, шийдвэр гаргагч нарыг оролцуулсан) зохион байгуулсан байна | Дүүрэг, орон нутгаас сонгож үйл ажиллагааг эхлүүлж олон нийтэд сурталчилсан байна | ЭМЯ НЭМҮТ | БШУЯ ХНХЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ ЭМБ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв 100,0 |
| 10. | Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрүүл мэндийн бусад тулгамдсан асуудлаар оюутан залуусын хэрэгцээнд нийцсэн нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээлэл бүхий албан ёсны веб хуудас ажиллуулах | | Оюутан залуусын дундах тулгамдсан асуудлыг судлан, гаргаж ирэх | Албан ёсны веб хуудасны загвар төсөл гарган, батлуулах | Албан ёсны веб хуудас ажиллуулж эхэлсэн байна | ЭХЭМҮТ НЭМҮТ | БШУЯ ХНХЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ ЭМБ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв 120,0 |
| 11. | Хэвлэл, мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд албан ёсны веб хуудсыг сурталчлах, таниулах арга хэмжээг зохион байгуулах | | Өргөн нэвтрүүлгийн сурвалжлагч, сэтгүүлч нарыг | Цахим сонин, фм радиогийн сурвалжлагч, сэтгүүлч нарыг | Орон нутгийн ХМ-ийн сурвалжлагч, сэтгүүлчийг | НЭМҮТ | БШУЯ ХНХЯ | Улсын төсөв 250,0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оролцуулсан сургалт зохион байгуулсан байна | оролцуулсан сургалт зохион байгуулсан байна | хамруулсан байна | | Аймаг, нийслэлийн ЗДТГ ЭМБ-ууд ОУБ-ууд | |
| 12. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асран хамгаалагч нарт өсвөр үеийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих хүрээнд өвөрмөц хэрэгцээнд нь тохирсон (баррель, аудио) сургалтын материал боловсруулж, хэвлэн, сурталчлах, түгээх үйл ажиллагааг зохион байгуулах | | Гарын авлагын агуулга хэвлүүлэх, үндэсний хэмжээнд түгээх, сургагч багшийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан байна | Тусгай хэрэгцээт сургууль, хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүд ажилладаг байгууллагад ажлын байраар дамжуулан сургалт зохион байгуулагдсан байна | | ЭМЯ НЭМҮТ | БШУЯ ХНХЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ ЭМБ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв 200,0 |
| 13. | Цэвэршилтийн үеийн амьдралын хэв маягийн онцлог, анхаарах асуудлын талаарх сургалт сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах | | Цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн амьдралын хэв маягийн талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах, орон нутгийн эмэгтэйчүүдийн төлөөллийг оролцуулсан нэвтрүүлэг хийсэн байна | Салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийг оролцуулсан зөвлөгөөнийг зохион байгуулж "Role model" сургалт, сурталчилгааг зохион байгуулсан байна | Цэвэршилтийн дараах бие махбодын өөрчлөлт, амьдралын хэв маяг, эмэгтэйчүүдэд чиглэсэн оролцоон дээр тулгуурласан үйл ажиллагааг улирал бүр нийслэлд зохион байгуулсан байна | НЭМҮТ | Геронтологийн үндэсний төв, Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд, Төрийн болон ТББ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв 160,0 |
| 14. | Хорих анги, асрамжийн газар хүмүүжиж буй охид, эмэгтэйчүүдэд бэлгийн болон нөхөн үржихүйн талаар эрүүл мэндийн боловсрол олгох талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах | | Бэлгийн болон нөхөн үржихүй, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр | Нийслэлийн хорих анги, асрамжийн газарт хүмүүжиж байгаа 100 эмэгтэйг оролцуулсан сургалт зохион байгуулж, | Өртөөлсөн байдлаар орон нутгийн хорих анги, асрамжийн газарт хүмүүжиж байгаа 100 эмэгтэйг оролцуулсан | ЭМЯ НЭМҮТ | ХЗЯ Аймаг, орон нутгийн ЗДТГ ЭМГ-ууд ТББ-ууд | Улсын төсөв 130,0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | боловсруулсан байна | гарын авлагаар хангасан байна | сургалт зохион байгуулах, гарын авлагаар хангасан байна | | | |
| **ЗОРИЛТ 5. Эх, ураг, нярай, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | | | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.1 Эх барих эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | | | | | | | | |
| 1. | ЭХЭМҮТ, амаржих газрууд, аймгийн төрөх, сэхээн амьдруулах тасгуудад эмнэлзүйн шуурхай хариу арга хэмжээний зайн оношилгоо, эмчилгээг хүргэх хиймэл оюун ухаан дээр суурилсан телемедициныг хөгжүүлэх | Хиймэл оюун ухаан дээр суурилсан телемедициний г хөгжүүлэх төслийн санал боловсруулсан байна. | Хиймэл оюун ухаан дээр суурилсан телемедициныг хөгжүүлэх орон нутгийн нөөц, бололцоог судлах | 10 аймаг, 2 амаржих газартТелемед ицинийг ашиглан тусламж, үйлчилгээ үзүүлдэг болсон байна | 11 аймаг, 1 амаржих газартТелемед ицинийг ашиглан тусламж, үйлчилгээ үзүүлдэг болсон байна | ЭМЯ ЭХЭМҮТ | ЭНЭҮТ-II Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд НҮБ-ын ХАС | Улсын төсөв<br>400.0 |
| 2. | Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал, хөх, дотоод шүүрлийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | | Хүний нөөц болон тоног төхөөрөмжөөр хангагдсан байна<br><br>Хөх, дотоод шүүрлийн кабинетуудын үйл ажиллагааг 3-5 газар эхлүүлсэн байна | Хөх, дотоод шүүрлийн кабинетуудыг орон нутагт үе шаттайгаар байгуулсан байна | Эмэгтэйчүүдийн дурангаар хийгдэх мэс заслын хувь нэмэгдсэн байна<br><br>Хөх, дотоод шүүрлийн кабинетуудыг үйл ажиллагааг тогтмолжсон байна | ЭМЯ ЭМХТ | ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II Амаржих газрууд Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд НҮБ-ын ХАС ТББ-ууд | ОУБ |
| 3. | Хүнд өвчлөл (severe morbidity) болон ноцтой хүндрэлийн бүртгэлийн тогтолцоог шинэчлэх, эмнэлзүйн аудитыг нэвтрүүлэх | | Эмнэлзүйн аудитыг боловсруулсан байна | Эмнэлзүйн аудитыг батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн байна | Хэрэгжилтэнд үнэлгээ хийж, танилцуулагдсан байна | ЭМЯ ЭХЭМҮТ | Мэргэжлийн салбар зөвлөл, холбоод | 10,0 |
| 4. | Амаржих газар, төрөх тасгуудад гэр бүлд түшиглэсэн "Имж эх" асаргааг хэрэгжүүлэх | | Сургалтын хөтөлбөр баталж, сургагч багш бэлтгэгдсэн байна | Амаржих газар, төрөх тасгуудын холбогдох мэргэжилтнүүдийн 50%-ийг | Амаржих газар, төрөх тасгуудын холбогдох мэргэжилтнүүдийн 90 хүртэл | ЭМЯ ЭХЭМҮТ | ЭНЭҮТ-II Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд НҮБ-ын ХАС | ОУБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сургалтад хамруулсан байна | хувийг сургалтад хамруулсан байна | | | |
| 5. | Амаржих газар, төрөх тасгуудыг эхийн сүүний нөөцийн банктай болгох | | Амаржих газруудад байгуулсан байна | Хүүхдийн эмнэлэгт байгуулсан байна | Аймгуудад байгуулсан байна | ЭМЯ ЭХЭМҮТ | ЭНЭҮТ-II ХӨСҮТ Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд НҮБ-ын ХАС ТББ-ууд | ОУБ |
| 6. | Тусгай хэрэгцээ шаардлагатай жирэмсэн эмэгтэйд тусламж үйлчилгээ үзүүлэх, төрүүлэх тоноглол бүхий төрөх өрөөг бий болгох | | Холбогдох шийдвэр гарч, санхүү, хүний нөөц, тоног төхөөрөмжийн бэлэн байдал хангагдсан байна | Нийслэлийн амаржих газруудад хэрэгжүүлж эхэлсэн байна. | Газар зүйн 4 бүс тус бүрээс 2 аймагт хэрэгжүүлсэн байна. | ЭМЯ ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II | ХНХЯ Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд НҮБ-ын ХАС ТББ-ууд | Улсын төсөв 400.0 |
| 7. | Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэн, жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх нөхөн сэргээх тусламж үйлчилгээний заавар боловсруулах үйл ажиллагаанд хэрэгжүүлэх | | Нөхөн сэргээх тусламж үйлчилгээний заавар боловсруулан, батлуулсан байна | Нөхөн сэргээх тусламж үйлчилгээний заавраын дагуу эмч, мэргэжилтнүүд эд сургалт хийсэн байна | Эмч, мэргэжилтнүүд нөхөн сэргээх тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон байна | ЭМЯ | ХНХЯ ХЗЯ ОУБ-ууд ЖҮХ | Улсын төсөв 20.0 |
| 8. | Эх баригчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр өргөжүүлж, чадавхижуулах | | Холбогдох шийдвэрт өөрчлөлт оруулж, төгсөлтийн дараах сургалтын агуулгыг шинэчилнэ | Шинэчилсэн хөтөлбөрөөр эх баригч нарын 80%-ийг сургалтад хамруулсан байна | Шинэчилсэн хөтөлбөрөөр эх баригч нарын 100% сургалтад хамруулсан байна | ЭМЯ ЭХЭМҮТ | АШУҮИС Амаржих газрууд Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд НҮБ-ын ХАС ТББ-ууд | ОУБ |
| 9. | Эх барихын үжил, халдвараас сэргийлэх, бууруулах цогц үйл ажиллагаа явуулах, WHO GLOSS хөтөлбөрийг хэрэгжүүлэх | | Хөтөлбөр боловсруулж, батлуулсан байна | Хөтөлбөрийн үр дүнг тооцсон байна | Улсын хэмжээнд хэрэгжсэн байна | ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл | ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II Амаржих газрууд | ОУБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Аймгийн ЭМГ-ууд АШУҮИС НҮБ-ын ХАС ТББ-ууд | |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.2 Нярай, хүүхдийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ** | | | | | | | | |
| 1. | Нярайн болон хүүхдийн эрт илрүүлгийг үе шаттайгаар нэмэгдүүлэх | | | | | | | |
| | • Нярайн бодисын солилцооны эмгэг<br>• Зүрхний төрөлхийн хүнд гажиг<br>• Хүүхдийн нүдний хавдрыг илрүүлэх улаан рефлексийн арга | | Нярайн (скрининг) Эрт илрүүлгийн заавар шинэчлэгдэн батлагдаж, сургалт зохион байгуулагдсан байна | Нярайн эрт илрүүлэг хэрэгжиж эхэлсэн байна | Нярайн эрт илрүүлэг бүрэн хэрэгжиж, үр дүнг тооцсон байна | ЭМЯ ЭХЭМҮТ | Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд АШУҮИС Мэргэжлийн нийгэмлэг холбоод | Улсын төсөв 100.0 |
| | • Сонсгол, дутуу нярайн ретинопати<br>• Түнхний дутмаг хөгжил | | Хэрэгжилтэд үнэлгээ хийгдсэн байна | Үнэлгээний үр дүнгийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлсэн байна | | | | Улсын төсөв 50.0 |
| 2. | Бага жинтэй болон дутуу төрсөн, өвчтэй нярайн менежмент хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Гарын авлагын төсөл боловсруулсан байна | Гарын авлага хэвлэгдсэн байна.<br>Үндэсний сургагч багш нар бэлтгэгдсэн байна | Амаржих газрууд, нийслэлийн 3 дүүрэг, 3 аймагт хэрэгжүүлсэн байна. | Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлсэн байна. | ЭМЯ ЭХЭМҮТ | НҮБХС АШУҮИС НЭМГ | Улсын төсөв 20.0 |
| 3. | Нярайн тусламж,үйлчилгээнд нотолгоонд суурилсан үр дүнтэй арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах | | | | | | | |
| | Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээг сайжруулах | 2020 оны хэрэгжилтэд үнэлгээ хийсэн байна. | 2022-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулсан байна | 2023 онд төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. | 2024 онд төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. | ЭМЯ Мэргэжлийн нийгэмлэг холбоод | Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв 50.0 |
| | Сурфактант эмчилгээний тусламж үйлчилгээг сайжруулах | | Сурфактант эмчилгээний хэрэгжилтэд | Үнэлгээний үр дүнгийн дагуу арга хэмжээ зохион | Сурфактант эмчилгээний үр дүн сайжирсан байна. | ЭМЯ Мэргэжлийн нийгэмлэг холбоод | Амаржих газрууд Аймгийн ЭМГ-ууд | Улсын төсөв 30.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үнэлгээ хийгдсэн байна | байгуулсан байна | | | ОУБ-ууд | |
| 4. | Дутуу нярай хүүхдийг 6 нас хүртэл хянах журам боловсруулах, хэрэгжүүлж эхлэх | | Журам боловсруулан батлуулсан байна | Журам хэрэгжиж эхэлсэн байна. Журмыг ЭМБ-уудад танилцуулсан байна | Журам хэрэгжсэн байна | ЭМЯ Мэргэжлийн нийгэмлэг холбоод | Амаржих газрууд Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ОУБ-ууд | - |
| 5. | Гэрийн эргэлт, товлолт үзлэгийн чанар, хүртээмжийг сайжруулах | | | | | | | |
| | Нэг хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлтийн журмыг шинэчлэх | | Нэг хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлтийн журам шинэчлэгдсэн байна | Шинэчлэгдсэн журмыг таниулах сургалтыг бүсчлэн зохион байгуулсан байна | Журам хэрэгжсэн байна. | ЭМЯ Мэргэжлийн нийгэмлэг холбоод | Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ОУБ-ууд | - |
| | ХӨЦМ-ийн хэрэгжилтэд дэмжлэгт хяналт хийх | | Сонгосон аймгуудад дэмжлэгт хяналт хийсэн байна | Дэмжлэгт хяналтын тайлангийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлсэн байна | Сонгосон аймгуудад дэмжлэгт хяналт хийсэн байна | ЭМЯ Мэргэжлийн нийгэмлэг холбоод | Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ТББ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв 20.0 |
| | 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, жирэмсний хөтөчийг шинэчлэн боловсруулах, дижитал хэлбэрт оруулах | Ажлын хэсэг батлагдсан байна.<br><br>Төслийг боловсруулсан байна. | Дижитал хэлбэрт оруулж, батлуулсан байна<br><br>Эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна<br><br>Эцэг, эх, олон нийтийн төлөөллийг хамруулсан сургалт, сурталчилгаа | Хэрэгжилтэд үнэлгээ хийгдсэн байна | Зөвлөмжийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлсэн байна | ЭМЯ ЭМХТ | Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд Мэргэжлийн нийгэмлэг холбоо ОУБ-ууд | Улсын төсөв 50.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулсан байна | | | | | |
| | Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх журмыг шинэчлэх | Журмыг шинэчлэх хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна. | Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх журам шинэчлэгдсэн байна | Шинэчлэгдсэн журмыг таниулах сургалтыг бүсчлэн зохион байгуулсан байна. Журам хэрэгжсэн байна | Журам хэрэгжсэн байна | ЭМЯ ЭХЭМҮТ ЭНЭҮТ-II | Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ОУБ-ууд Мэргэжлийн нийгэмлэг холбоод | - |
| 6. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах | | | | | | | |
| | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэл мэдээллийг сайжруулах журмыг шинэчлэх | | Журам шинэчлэгдсэн байна | Шинэчлэгдсэн журам хэрэгжиж эхэлсэн байна | Журмын хэрэгжилтэнд үнэлгээ хийгдсэн байна | ЭМЯ ЭХЭМҮТ ЭМХТ | ХНХЯ Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд Мэргэжлийн нийгэмлэг холбоод ОУБ-ууд | - |
| | Байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн шалгуур үзүүлэлт, аргачлалыг шинэчлэн боловсруулах | Хамтарсан ажлын хэсэг байгуулагдан шалгуур үзүүлэлт, аргачлалыг шинэчлэн боловсруулсан байна | Шалгуур үзүүлэлт, аргачлал шинэчлэн боловсруулагдсан байна | Хэрэгжиж эхэлсэн байна | | ЭМЯ | ХНХЯ ХСМСЗ Мэргэжлийн нийгэмлэг холбоод | - |
| | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэгт хамруулах чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнг сургах | | Сургагч багш бэлтгэгдэн, АШЭМБ-ын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна | АШЭМБ-ын ажилтнуудад сургалт зохион байгуулагдсан байна | Хэрэгжилтэд үнэлгээ хийгдсэн байна | ЭМЯ | ХНХЯ Мэргэжлийн нийгэмлэг холбоод ОУБ-ууд | Улсын төсөв 60.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт үеийн нөхөн сэргээх эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт үеийн нөхөн сэргээх эмчилгээний чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэсэн байна<br><br>Эрт үеийн нөхөн сэргээх эмчилгээний нэгжийг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна | Хүүхдийн хөдөлгөөн засалч эмч, сувилагчийг бэлтгэсэн байна<br><br>Хөдөлгөөн заслын тоног төхөөрөмжөөр хангагдан, үйл ажиллагаа эхэлсэн байна | Эрт үеийн нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээг цогцоор үзүүлдэг болсон байна | ЭМЯ ЭХЭМҮТ ЭМХТ | Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ХБХСЗХТ Мэргэжлийн нийгэмлэг холбоо ОУБ-ууд | - |
| 7. | Хүүхдийн яаралтай тусламж, үйлчилгээг сайжруулах | | | | | | | |
| | Хүүхдийн яаралтай тусламжийн эмнэлзүйн зааврыг шинэчлэн боловсруулах | Журам боловсруулах ажлын хэсэг батлагдсан байна | Журам шинэчлэгдсэн байна.<br><br>Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд танилцуулах сургалт зохион байгуулсан байна | Хэрэгжилтэд үнэлгээ хийгдсэн байна | | ЭМЯ Мэргэжлийн нийгэмлэг, холбоод | Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ОУБ-ууд | - |
| | Аймаг, нийслэлийн Нэгдсэн эмнэлгийн хүлээн авах яаралтай тусламжийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх | Үнэлгээний загвар төсөл гарсан байна | Үнэлгээ хийгдэж, зөвлөмж гарсан байна | Зөвлөмжийн дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна | | ЭМЯ Мэргэжлийн нийгэмлэг, холбоод | Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ОУБ-ууд | Улсын төсөв<br><br>20.0 |

--- o0o ---

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 09 ний өдрийн А/760 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# “ЭХ ХҮҮХЭД НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

“Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2019, 2020 оны мэдээллийг суурь үзүүлэлт болгон ашигласан.

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин 2020 | Хүрэх түвшин (оноор) | | | | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| | **I. Үр нөлөөний шалгуур үзүүлэлт** | | | | | | | |
| 1 | Эхийн эндэгдлийн түвшин | 100000амьд төрөлтөд | 23* | 21.4* | 20.6 | 19.8 | 19 | Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| 2 | 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн түвшин | 1000 амьд төрөлтөд | 14.0* | 13.2* | 12.4 | 12.1 | 11.8 | |
| 3 | Нялхсын эндэгдлийн түвшин | 1000 амьд төрөлтөд | 13.3* | 12.3* | 11.8 | 11.3 | 10.8 | |
| 4 | Нярай эндэгдлийн түвшин | 1000 амьд төрөлтөд | 7.8* | 7.3* | 6.8 | 6.3 | 5.8 | |
| 5 | Перинаталь эндэгдлийн түвшин | 1000 нийт төрөлтөд | 11.1* | 10.9* | 10.7 | 10.5 | 10.3 | |
| | **II. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт** | | | | | | | |
| 6 | Жирэмсний эрт үеийн хяналтын хувь | Хувь | 89.9* | 90* | 91 | 92 | 93 | |
| | Жирэмсний хугацаанд 6 болон түүнээс дээш үзүүлсэн эхийн эзлэх хувь | Хувь | 79.5* | 76.5* | 73.5 | 70.5 | 67.5 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувь | Хувь | 53.9* | 55.2* | 56.5 | 57.8 | 59.1 | Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| 8 | Жирэмслэхээс сэргийлэх 5- аас доошгүй эм хэрэгслээр үйлчилж байгаа анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хувь | Хувь | 90.0* | 91.0* | 92.0 | 93.0 | 94.0 | |
| 9 | 15-19 насны охидын төрөлтийн түвшин | 15-19 насны 1000 охидод | 27.7* | 24.8* | 21.9 | 19.0 | 16.1 | |
| 10 | Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын түвшин | 100000 амьд төрөлтөд | 48.5* | 43.5* | 38.5 | 33.5 | 28.5 | |
| 11 | Үр хөндөлтийн түвшин | 1000 амьд төрөлтөд | 191.7* | 186* | 181 | 176 | 171 | |
| 12 | Осол гэмтлээс шалтгаалсан 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол | тоо | 150* | 140* | 130 | 120 | 110 | |
| 13 | 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэлд уушгины хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын эзлэх хувь | Хувь | 7.1* | 6.1* | 5.0 | 4.0 | 3.0 | |
| 14 | 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллосон хүүхдийн эзлэх хувь | Хувь | 50.2** | 52.9** | 55.6 | 58.3 | 61 | ҮСХ |
| 15 | Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь | Хувь | 98.9 | 98.9 | 99 | 99 | 99 | ХӨСҮТ |
| **III. Эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлт** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | Нярайн эрт илрүүлэг, төрөх өрөөнд нярайн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт | Байгууллагын тоо | Үе шаттай хангаж эхэлсэн байна | 7 аймаг 1 амаржих газрыг бүрэн хангасан байна | 7 аймаг 1 амаржих газрыг бүрэн хангасан байна | 7 аймаг 1 амаржих газрыг бүрэн хангасан байна | 7 аймаг 1 амаржих газрыг бүрэн хангасан байна | ЭМЯ ЭХЭМҮТ НЭМҮТ БСШУЯ |
| 17 | Өсвөр үеийнхэнд үе тэнгийн зөвлөгч бэлтгэх | | - | - | 10 аймаг, 9 дүүрэгт | 11 аймаг, 9 дүүрэгт | 21 аймаг, 9 дүүрэгт Үе тэнгийн сургагч бэлтгэгдсэн байна | |
| 18 | Хийсвэр хагалгааны дараах ноцтой хүндрэлийн хувь | Хувь | 24.8 | 20 | 15 | 10 | 5 | |

**Тайлбар: Мэдээллийн эх үүсвэр**

** Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2019, 2020, 2021 он*

*** Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018*

--- o0o ---